

**“БУЛИГААР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 07/24

Улаанбаатар хот

**Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагаа
болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын санал хураасан дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Нэг. Булигаар ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг хэлэлцэн цаашид компанийн бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг уялдуулан “сайжруулах шаардлагатай” гэж дүгнэсүгэй.
- Хоёр. Энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралт дахь дүгнэлтийг 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



А.ЭНХМЭНД

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2024 оны 03-р сарын 12-ны өдрийн
07/24 тоот тогтоолын Хавсралт 1

БУЛИГААР ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

УЛААНБААТАР ХОТ
ХТҮ5403 8022080051 2039184

Булигаар ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Булигаар ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Булигаар ХК нь 2023 онд 11 тэрбум төгрөгийн борлуулалтын төлөвлөгөөтэй ажилласан бол бодит гүйцэтгэлээр 7,206.9 сая төгрөгийн борлуулалт хийж, борлуулалтын төлөвлөгөө 65 хувийн биелэлтэй ажиллаж, өмнөх оноос 16 хувиар буурсан байна.

2023 онд нийт 299 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 17.4 хувийг үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмж, 29.4 хувийг тоног төхөөрөмжийн урсгал засвар, 38.1 хувийг барилга байгууламжийн бүтээн байгуулалт, 11% хувийг бусад хөрөнгө оруулалтад зарцуулсан байна.

Тус компани өнгөрсөн онд нийтдээ 8,537,653,532.34 төгрөгийн орлого олсон. Тайлант хугацаанд өнгөрсөн оныхоос 1,330,700,714.30 төгрөгөөр борлуулалт буурсан байна. Тайлант хугацаанд 1,729,082,097.95 төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 192,297,580.08 төгрөгөөр өссөн бөгөөд үүнээс үйл ажиллагааны зардлын 722,300,315 төгрөгийг ашиглалтад, 88,221,606 төгрөгийг урсгал засвар хийхэд, 728,107,632 төгрөгийг зээлийн хүүгийн зардалд зарцуулсан байна.

Тайлант үеийн жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 33,957,389,082.25 төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 45.4 хувь буюу 15,416,088,640.32 төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 54.6 хувь буюу 18,541,300,441.93 төгрөгийг эзэлж байна.

Эргэлтийн хөрөнгийн 0.14 хувь буюу 22,914,287.62 төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 61.26 хувь буюу 9,445,382,624.47 төгрөг бараа материалд, 32.5 хувь буюу 5,015,778,458.74 төгрөг урьдчилж төлөгдсөн зардалд 6.04 хувь буюу 932,013,269.49 төгрөг эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 95.1 хувь буюу 17,641,055,093.24 төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 1.9 хувь буюу 359,473,988.31 төгрөгийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 22,294,624,890.31 төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн 11,662,764,191.94 төгрөг байна. Нийт өр төлбөрийн 26.4 хувь буюу 5,893,279,577.17 төгрөгийг богино хугацаат өр төлбөр, 73.6 хувь буюу 16,401,345,313.14 төгрөгийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Эзэмшигчдийн өмч оны эхэнд 11,727,544,902.86 төгрөг байсан бол оны эцэст 11,662,764,191.94 төгрөг болж буурсан байна.

Гүйцэтгэх удирдлагын баг 2023 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж, хэтийн зорилгодоо хүрэх, компанийн хөгжлийг урагшлуулах алхмуудыг хийж, бизнесийн орчны өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд зах зээлийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Иймд “Булигаар” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс 2023 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланд “сайжруулах шаардлагатай” гэсэн дүгнэлт өгч байна.